



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 23 болон 24 дахь долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 06-р сарын 07-ноос 06-р сарын 18-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас 2 долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 9 дэх дугаарыг хүргэж байна.

1

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Дэлхийн банк 2021 оны 6-р сарын “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайландаа дэлхийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөх 1-р сарын төсөөллөөс 1.5 хувиар сайжруулж 5.6 хувьд хүргэв. Цар тахлаас шалтгаалан улс орнуудын эдийн засгийн сэргэлт харилцан адилгүй байхаар байна. Тухайлбал, томоохон улс орнууд болох АНУ (6.8%), БНХАУ (8.5%)-ын эдийн засгийн өсөлт эрчимжих нь дэлхийн эдийн засгийн өсөлтөд гол нөлөөг үзүүлж, хөгжингүй орнуудын ихэнх нь 2022 он гэхэд цар тахлын өмнөх

түвшинд хүрэхээр байгаа бол эрчимтэй хөгжиж буй болон хөгжиж буй улс орнуудын дундаж өсөлтийн төсөөлөл 2.9 хувь буюу 2022 он гэхэд эдгээр орнуудын дөнгөж гуравны нэг нь л цар тахлын өмнөх түвшинд хүрэхээр байна. Түүнчлэн, дэлхийн эдийн засаг бүрэн сэргэхэд вакцины тэгш хүрэлцээг нэмэгдүүлэх чухал байгаа, бодлого боловсруулагчид эдийн засгийн хөгжлийг илүү ногоон, хүрэлцээтэй өсөлтөд чиглүүлэхэд анхаарах хэрэгтэйг онцоллоо.

Хүснэгт 1. Дэлхийн томоохон санхүүгийн байгууллага, олон улсын агентуудын дэлхийн эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллүүд

	Эх сурвалжууд	Төсөөлөл хийсэн огноо	2021 он				
			Дэлхийн эдийн засгийн өсөлт	БНХАУ-ын өсөлт	АНУ-ын өсөлт	Евро бүс өсөлт	ОХУ-ын өсөлт
1	Дэлхийн банк	6/15/2021	5.6%	8.5%	6.8%	4.2%	3.2%
2	Fitch агентлаг	6/15/2021	6.3%	8.4%	6.8%	5.0%	
3	Scope агентлаг	6/17/2021	6.0%	9.2%	6.2%	4.7%	3.0%
4	Conference board	6/09/2021	5.3%	8.6%	6.6%	4.2%	3.4%

Эх сурвалж: Төсөөлөл хийсэн байгууллагуудын цахим хуудсууд



- **Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Фитч агентлагаас 6-р сард дэлхийн эдийн засгийн төлөвийг шинэчиллээ.** Тодруулбал, 2021 онд дэлхийн эдийн засгийн өсөлт 6.3 хувьд хүрэхээр байгаа нь өмнөх 3-р сарын төсөөллөөс 0.2 хувиар сайжирсан дүн юм. Үүнд, АНУ-ын эдийн засаг 6.2 хувиас нэмэгдэж 6.8 хувь, Евро бүс 4.7 хувиас 5.0 хувь, Их Британи 5.0 хувиас 6.6 хувийн өсөлтийг тус тус үзүүлэхээр байгаа нь голлон нөлөөлөв. Харин БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл өмнөхөөс өөрчлөлтгүй 8.4 хувь хэвээр байна. АНУ, Евро бүсэд үргэлжилж буй вакцинжуулалтын нөлөөгөөр хөл хорио суларч, шинээр бүртгэгдэх цар тахлын тохиолдол буурч буй, Засгийн газар, Төв банкнаас эдийн засгийг дэмжих бодлогуудын үр нөлөөгөөр үйлчилгээний салбар хүлээлтээс хурдтай сэргэж байгаа нь төсөөллийг нэмэгдүүлэхэд нөлөөллөө. АНУ-д удаан эдэлгээт бараа, бүтээгдэхүүний хэрэглээ цар тахлын өмнөх түвшнээс 30 хувиар өсч, түүнийг дагасан импорт мөн нэмэгдсэн нь эрчимжиж буй эдийн засагтай орнуудын экспортыг дэмжиж байна.
- **ОХУ-ын эдийн засаг 2021 оны 1-р улиралд 1 хувиар агших тооцоололтой байсан бол 0.7 хувиар агшжээ.** SOVA capital байгууллагаас 2021 оны өсөлтийн төсөөллийг 3.4 хувь болгон сайжруулсан нь эхний 4 сарын эдийн засгийн өсөлт хүлээлтээс өндөр байсантай холбоотой гэж тус байгууллагын ерөнхий эдийн засагч Артем Зайгрин мэдээллээ. Энэ оны 1-р улиралд хөл хориог сулруулсантай холбоотойгоор аж үйлдвэрлэл, жижиглэн, бөөний худалдаа сэргэж, хувийн хэрэглээ нэмэгдсэн нь эдийн засагт эерэгээр нөлөөлсөн байна. Түүнчлэн, тус улсын Төв банк 2021 оны 6-р сард инфляцын өсөлттэй уялдуулан бодлогын хүүгээ 5.5 хувь хүртэл нэмэгдүүлсэн бөгөөд цаашдаа мөн өсгөх хүлээлттэй байна.
- **ОХУ баялгийн сангийн 119 тэрбум ам.долларыг евро, юань, алт руу хөрвүүлэх тухай тус улсын сангийн сайд Антон Силуанов мэдээллээ.** Энэ нь АНУ-аас ОХУ-д тавьж буй хоригоос үүдэх эрсдэлээс сэргийлэхийн зэрэгцээ ам.доллараас хараат бус байх шийдвэр ажээ.
- **АНУ-ын Холбооны нөөцийн банк бодлогын хүүг 2023 оны сүүлээр 0.6 хувьд хүргэх төлөвтэй байна.** АНУ-ын эдийн засаг 2021 онд 7.0 хувиар өсөх, ажилгүйдлийн түвшин 4.5 хувьд хүрэх, суурь инфляцын түвшин 3 хувьд хүрэх төсөөлөлдөө үндэслэн АНУ-ын Холбооны нөөцийн банк 2021 оны 6-р сард бодлогын хүүгээ 0.0-0.25 хувьд хэвээр хадгалах, сар тутам 120 тэрбум ам.долларын бонд худалдан авах хөтөлбөрөө цаашид үргэлжлүүлэхээр шийдвэрлэв. Мөн 2022, 2023 онуудад эдийн засгийн өсөлт тогтворжиж, ажилгүйдлийн түвшин 3.5 хувь хүртэл буурах төлөвтэй тул 2022 оны төгсгөл хүртэл бодлогын хүүгээ тэг орчим хувьд, 2023 онд хоёр удаа өсгөх чиглэлтэй буюу өмнөх улирлын хүлээлттэй харьцуулахад хүү өсгөх хугацаагаа наашлуулаад байна.
- **Япон улсын хувийн хэрэглээ агшсанаар эдийн засаг нь 2021 оны 1-р улиралд 3.9 хувиар буурав.** Хувийн хэрэглээний өсөлт сул байгаа нь дотоодын эрэлтэд сөргөөр нөлөөлж байгаа хэдий ч вакцинжуулалтыг 50 хувьд хүргэснээр бизнесүүд идэвхжиж, эдийн засаг сэргэх төлөвтэй байгаа тухай Norin Chukin судалгааны байгууллагын ерөнхий эдийн засагч Такэши Минами мэдээллээ. 2021 оны 1-р улиралд Засгийн газрын зарцуулалт 1.8 хувиар буурах төсөөллөөс сайжирч 1.1 хувиар буурсан байна. Харин

хувийн хэрэглээ 1.4 хувиар агших төсөөллөөс 0.1 хувиар муудаж 1.5 хувиар агшчээ. Харин банкны зээлийн өсөлт 4-р сард 4.8 хувь, 5-р сард 2.9 хувийн өсөлттэй байв. Түүнчлэн 4-р сард инфляцтай уялдсан бодит цалингийн өсөлт 2.1 хувьд хүрэв.

- **Канад улс дулааны нүүрс олборлогчдод тавих шаардлагаа чангатгав.** Тухайлбал, байгаль орчныг хамгаалах чиглэлд дулааны нүүрс олборлолтын тусгай зөвшөөрөл шинээр олгохгүй байх, одоо байгаа нүүрс олборлогчдын хайгуулын үйл ажиллагааг өргөтгөхгүй байх шийдвэрийг тус улсын Байгаль орчны

сайд **Жонатан Вилкинсон** танилцуулав.

Эх сурвалж:

1. The World Bank, [Global Economic Prospects - June 2021](#)
2. Business Standard, [Russia cuts US dollar holdings in \\$119-billion wealth fund to zero](#)
3. Reuters, [Canada will not approve new thermal coal mining projects, cites environmental damage](#)
4. The Wall Street Journal, [Fed Pencils In Earlier Interest-Rate Increase](#)
5. FocusEconomics, [Russia: GDP contracts less than initially estimated in Q1](#)
6. The Conference Board, [Global Economic Outlook](#)
7. Fitch Ratings, [Global Outlook – June 2021](#)
8. Scope Ratings, [June 2021 Sovereign Intern Outlook](#)
9. Aljazeera, [Japan economy shrinks in first quarter - but less than expected](#)
10. FRB, [Federal Reserve press release](#)

- **БНХАУ-ын эрх баригчид мөнгөний бодлогыг нормальчлах (normalization) бодлого баримталж мөнгөний бодлогын төлөвөө алгуур чангаруулах хүлээлттэй байна.** БНХАУ-ын Ардын Банк (ХАБ)-аас бодлогын хүү (1 жилийн хугацаатай LPR хүү)-г 2021 оны 6-р сард 3.85 хувьд, 1 жилийн хугацаатай дунд хугацааны зээлийн хэрэгслийн хүүг 2.95 хувьд, 5 жилийн хугацаатай орон сууцны зээлийн жишиг хүүний түвшинг 4.65 хувьд тус тус хэвээр үлдээснээр хүүний түвшин сүүлийн 14 сар тогтвортой байна. Хүүний одоогийн түвшин нь эдийн засгийн сэргэлтийг дэмжихийн зэрэгцээ алгуур мөнгөний бодлогыг нормальчлах чиглэл баримтлах, болзошгүй эрсдэлээс сэргийлэхэд тохиромжтой түвшин бөгөөд инфляц энэ онд 2 хувиас доогуур хадгалагдах төлөвтэй гэж ХАБ-ны Ерөнхийлөгч И Ганг

мэдэгдэв. БНХАУ-ын үйлдвэрлэгчдийн үнийн индекс 2021 оны 5-р сард өмнөх оны мөн үеэс 9 хувиар өссөн бол ХҮИ-ээр хэмжигдэх инфляц жилийн 1.3 хувь байв. Эдийн засгийн сэргэлт үргэлжлэх төлөв хэвээр хэдий ч 5-р сарын тоон үзүүлэлтүүд дотоод эдийн засгийн сэргэлтийн хурдац оргил үеэ давсныг илэрхийлж байх боломжтой гэж Блүүмбергийн шинжээчид дүгнэв. ХАБ энэ оны туршид хүүг одоогийн түвшинд хэвээр хадгалах, цаашид мөнгөний бодлогоо нормальчлах зарчим баримтлан, бодлогын төлөвөө алгуур чангаруулах хүлээлттэй байна.

- БНХАУ-ын дотоод эдийн засгийн идэвхжил 5-р сард үргэлжилж, цаашид хадгалагдах төлөвтэй байгаа хэдий ч эдийн засгийн огцом сэргэлтийн үе дуусч, өсөлт тогтворжих хандлагатай боллоо. Үүнд:



- **Аж үйлдвэрлэлийн салбар дахь үйлдвэрлэл** 4-р сард өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар өссөн бол 5-р сард хүлээлтээс доогуур буюу 8.8 хувиар өсөв. Үүнд:
 - Боловсруулах салбар 4-р сард жилийн 10.3 хувиар, 5-р сард 9 хувиар өсөв. Мөн автомашины үйлдвэрлэл 4-р сард жилийн 7.7 хувиар өссөн ч 5-р сард 0.5 хувиар өсч өсөлт нь буурчээ. Ган үйлдвэрлэл 4-р сард жилийн 10.9 хувиар өссөн бол 5-р сард 7.7 хувь хүрч өсөлт бага зэрэг удааширсан байна. Харин эм үйлдвэрлэлийн өсөлт 4-р сард жилийн 19 хувьтай байсан бол 5-р сард 34 хувьд хүрч өсөлт эрчимжсэн нь боловсруулах салбарын өсөлтөд голлон нөлөөлөв.
- **Үл хөдлөх салбар дахь хөрөнгө оруулалт** оны эхний 5 сард 15.4 хувиар өссөн нь оны эхний 4 сарын 19.9 хувийн өсөлтөөс бага өсөлт байв. Үүнд:
 - Төсвийн дэд бүтцийн салбар дахь хөрөнгө оруулалт үргэлжилснээр төсвийн хөрөнгө оруулалт оны эхний 5 сард өмнөх оны мөн үеэс 11.8 хувиар өссөн бол хувийн сектор дахь хөрөнгө оруулалт эрчимжиж оны эхний 5 сард өмнөх оны мөн үеэс 18.1 хувиар нэмэгдсэн нь өсөлтөд дэмжлэг болов.
- Өсөлт удаашрахад оны эхний саруудад санхүүжилтийн гол эх үүсвэр болох тусгай зориулалттай бонд олголт удааширсан нь голлон нөлөөллөө. Тус бондын хэмжээ оны 2-р хагаст нэмэгдэж дэд бүтцийн олон төслүүдэд дэмжлэг болох хүлээлттэй байна.
- **Жижиглэн худалдаа** 4-р сард өмнөх оны мөн үеэс 17.7 хувиар өссөн бол 5-р сард 12.4 хувиар өслөө. Үүнд:
 - Хоол хангамжийн (эйтеринг) үйлчилгээний эрэлт нэмэгдэж борлуулалт 5-р сард өмнөх оны мөн үеэс 26.6 хувиар, 2 жилийн нийлмэл (2 year compound growth rate) өсөлтийн түвшнээр өмнөх оны мөн үеэс 1.4 хувь нэмэгдсэн нь өрхийн хэрэглээ идэвхжсэнийг илтгэж байна.
 - Жижиглэн худалдаа 2 жилийн нийлмэл өсөлтийн түвшнээр (two year basis, compound growth rate) 4-р сард 4.8 хувиар, 5-р сард 4.9 хувиар тус тус өслөө.

Эх сурвалж:

1. [China React: Rapid-Recovery Stage Over, Activity holding up, Bloomberg](#)
2. [China React: Steady LPRs show PBOC not irked by Inflation Pickup, Bloomberg](#)

Бодит гүйцэтгэл							
	Үнэ (-1 day) 2021/06/21	Өөрчлөлт					Товч тайлбар
		daily	weekly	monthly	year to date	YoY	
Зэс	9154	0.0%	-4.0%	-7.2%	18.1%	56.2%	КОВИД-19-ийн халдварын тархалт зарим орнуудад эрчимжиж байгаа ч улс орнуудад вакцинжуулалт үргэлжилж буй нь зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж байна. ВНР Group-ийн зүгээс тавьсан цалин урамшууллын саналыг нийт ажилчдын 92 хувь нь хүлээн авснаар Чилид болж өнгөрсөн ажил хаялт зогссонтой холбоотойгоор зэсийн үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс буурахад нөлөөлөв.
Төмрийн хүдэр	215.7	0.0%	0.6%	6.6%	41.1%	116.8%	БНХАУ энэ онд барилгын салбараа эрчимтэй дэмжих хүлээлтийн улмаас төмрийн хүдрийн эрэлт өндөр байх төлөвтэй. Мөн БНХАУ-ын боомтууд дахь нөөц өмнөх долоо хоногийн түвшнээс буурсан нөлөөгөөр үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс нэмэгдэхэд нөлөөлөв.
Алт	1783.2	-0.2%	-4.3%	-5.4%	-6.3%	1.4%	Хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа нь алтны эрэлт, үнэ өндөр байхад нөлөөлж байна. АНУ-ын ХНБ 6-р сарын хурлаараа мөнгөний бодлогын төлөвийг хүлээлтээс өмнө чангаруулж болзошгүй гэсэн мэдэгдэл алтны үнэ өмнөх долоо хоногоос буурахад нөлөөлөв.
Газрын тос (Брент)	74.9	-0.3%	0.9%	12.4%	46.2%	73.3%	Дэлхийн эдийн засгийн идэвхжил үргэлжилснээр эрэлт хүлээлтээс ихээр нэмэгдэх төлөв нь газрын тосны үнийг өмнөх долоо хоногоос өсгөх чиглэлд нөлөөлж байна.